

## Хортой сүү Монголд орж ирчихсэн юм биш үү

2013 оны 8 сарын 19

Like Share 3 Tweet 3 Түгээх 0 Хэвлэх Илгээх

### -М.Маккалли “мах, сүүний” айлчлалдаа Монголыг юуны учир багтаав-

Шинэ Зеланд улсын “Fonterra” компанид 2012 оны тавдугаар сард үйлдвэрлэгдсэн “WPC80” код бүхий шар сүүний уургийн хатаасан бэлдмэл Clostridium botulinum нянгаар бохирдсон талаар олон улсын хэвлэл мэдээллээр шуугиж байгаа билээ.



Үүнтэй холбогдуулан МХЕГ-ын даргын гаргасан удирдамжийн дагуу дээрх бэлдмэлээр үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн манай улсад худалдаалагддаг эсэх талаар судалгаа явуулж буй. Энэхүү шалгалтын хариу одоогоор гараагүй.

Энэхүү асуудал хэрэглэгчдийн анхаарлын төвд байх үед Шинэ Зеландын Гадаад харилцааны сайд М.Маккалли манай улсад албан ёсны айлчлал хийхээр болжээ. Азийн орнуудаар хийх түүний албан ёсны айлчлалын хөтөлбөрт манай улс багтсан байна. Хамгийн сонирхолтой нь түүний энэ айлчлал нь хортой сүүний асуудлаас болж хямарч

байгаа сүүний экспортоо сэргээхэд оршиж байгаа явдал юм.

Тэрбээр манай улсаас гадна БНХАУ, Хонгконгод айлчлах бөгөөд гол зорилгоо “Тун саяхан манай улстай холбоотой үүссэн мах, сүүний бүтээгдэхүүний талаарх шуугианд үнэн бодит хариулт өгөх явдал” хэмээн тодорхойлсон байна. Өөрөөр хэлбэл, тэрбээр энэхүү айлчлалаараа алдагдсан нэр хүндээ сэргээх, экспортлогч орнуудыг ятган сэнхрүүлж, зах зээлээ эргүүлэн олох зорилго тавьжээ.

М.Маккалли БНХАУ-д Гадаад хэргийн сайд Ван, улсын зөвлөх Ян Цжечи нартай уулзах юм. “Манай хоёр улсын харилцаа зөвхөн худалдаа гэлтгүй маш өргөн хүрээтэй. Тухайлбал Номхон далайн бус нутгийн асуудлаар ярих зүйл их бий” гэж хэлжээ.

Энэ бол Шинэ Зеланд сүүн бүтээгдэхүүнийхээ зах зээлийг сэргээхийн тулд бас нэгэн хөзөр дэлгэн тавихад бэлэн байгаагаа илэрхийлсэн үг гэж ойлгож болох юм. БНХАУ-ын хувьд стратегийн ач холбогдолтой байж болох Кукын арлуудын талаар тэрбээр хальт дурсаад өнгөрсөн нь үүнийг батална.

Харин манай улсад ирээд Монгол Улсын Ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдоржид бараалхахаас гадна Гадаад харилцааны сайд Л.Болдтой уулзаж, ажил хэрэгч яриа өрнүүлэхээр төлөвлөжээ. Албан ёсны мэдээлэлд хөдөө аж ахуй, боловсролын салбарт хамтрах асуудлыг хэлэлцэнэ гэсэн байна. Хонгконгод бол бизнес төлөөлөгчидтэй л уулзахаар төлөвлөсөн байна.

Манай улсын хувьд Шинэ Зеландын хортой сүү одоогоор илрээгүй боловч зөвхөн импортлогч компаниудын үгээр явж байгаа. Тэд бүтээгдэхүүндээ шар сүүний уураг ашигладаггүй гэж мэдэгдэж байгаа юм. Гэхдээ хортой сүүг экспортлогч улсын Гадаад хэргийн сайд нь яг энэ асуудлаар хийж буй айлчлалынхаа хөтөлбөрт манай улсыг багтаажээ.

Эх сурвалж: [www.mminfo.mn](http://www.mminfo.mn)

Х.Сайхан

[Эхлэл хуудас руу үсрэх](#)

Сэтгэгдэл бичих

Бидэнтэй нэгдээрэй [www.facebook.com/mminfo](http://www.facebook.com/mminfo) хуудсыг дэмжээрэй

Like 47,195 people like this. Sign Up to see what your friends like.

Follow @MminfoMN 1,865 followers



### Шинэ

- Н.Номтойбаяр МАН-ын бүлгийн дэд дарга боллоо  
Өнөөдөр 17 цаг 18 минут
- МАХН Удирдах ажилтнуудын зөвлөгөөнөө хийж байна  
Өнөөдөр 16 цаг 48 минут
- С.Бямбацогт: Нэн чухал хуулийн төслүүдээр УИХ-ын төвшинд зөвшилцөнө  
Өнөөдөр 15 цаг 19 минут
- Улстөрийн намын тухай хуульд өөрчлөлт оруулах хүрээнд өмчийн асуудал маргаан дагуулж байна  
Өнөөдөр 15 цаг 18 минут
- Олон улсын хүрээлэнгийн суурин төлөөлөгчтэй уулзав  
Өнөөдөр 15 цаг 16 минут
- Ж.Батзандан гишүүн хоёрдугаар эмнэлгийг дарга нарынх биш ард иргэдийг болгоно гэв  
Өнөөдөр 15 цаг 14 минут
- “Өглөөний цай” клубынхэн Ашигт малтмалын хуулийн төслийг хэлэлцжээ

[Их уншсан](#) [Их сэтгэгдэлтэй](#)

**sodon** МОНГОЛ



**Monitoring.mn**  
Хэвлэл мэдээллийн хүчирхэг зэвсэг

ВЭБ САЙТ  
FACEBOOK  
Сэтгэгдэл  
Twitter

Сонин хачин

Follow @mglnews



Автомашингүй хотын төв



Крис Полын шилдэг 5 бөмбөг таслалт (2013-2014)



Гарцаар гарахгүй байгаа иргэдийг торгоё!



Дэлхийн хамгийн сонирхолтой газруудад үйл ажи



iPhone 6 ухаалаг утасны талаарх цуурхал



Хөмсөгний тухай товчхон



Хятадад хямрал эхэлсэн үү?



Үрчлээний эсрэг хямд төсвөөр тэмцэцгээе!



Сэтгэгдэл (0)

**АНХААРУУЛГА:** Уншигчдын бичсэн сэтгэгдэлд mminfo.mn хариуцлага хүлээхгүй болно. ХХЗХ-ны журмын дагуу зүй зохисгүй зарим үг, хэллэгийг хязгаарласан тул ТА сэтгэгдэл бичихдээ хууль зүйн болон ёс суртахууны хэм хэмжээг хүндэтгэнэ үү. Хэм хэмжээг зөрчсөн сэтгэгдлийг админ устгах эрхтэй. Сэтгэгдэлтэй холбоотой санал гомдлыг **99998796** утсаар хүлээн авна.

Сэтгэгдэл:

Нэр:

Илгээх

Одоогоор сэтгэгдэл бүртгэгдээгүй байна.

- Энэ улс оронд юу болоод байна вэ?
- Нүд хужирлам тачаангуй бүсгүйчүүд
- ОХУ-ыг шөнийн цэнгээний газрууд нэг иймэрхүү...
- Бүсгүйчүүд согтохоороо
- Гурван хүүхэд төрүүлсэн ч тэр сайхан хэвээрээ
- Халаасны хулгайчидтай хамтарч ажилладаг кондукторыг баривчилжээ
- Экс Ерөнхийлөгч Н.Энхбаяр Солонгос улсад хүүхдүүд баярлуулав
- Далай аварга цолыг хаслаа
- Хөгжөөнтэй хөдөлгөөнт зурагнууд
- Хятадууд хүн оршуулахдаа

**MMINFO.MN**  
Шүүрэг, Шүүрэг, Саяаг мэдэхийн

**Татаж авах**

Та энэхүү **TOOLBAR** –ийг татаж авснаар илүү хурдан хандах боломжтой.


**Өөрийн үнэт цагаа хэмнээрэй**

**Mminfo MN**  
Like

47,195 people like Mminfo MN.




Facebook social plugin






Өвдөршаймдрал

“Алтай констракшн”-ы Х.Бат-  
Эрдэнэцаадмын хамжээтэй найр  
хийх гэнэ



Амралтын булан

Эмоци - Шарталт



Амралтын булан

Шинэ үе - Принцесс

[Эхлэл](#)

[Мэдээ](#)

[Ярилцлага](#)

[Нийтлэл](#)

[Халуун сэдэв](#)

[Ерөнхийлөгч](#)

[УИХ](#)

[Засгийн газар](#)

[Намууд](#)

[Улстөрч](#)

[Сонгууль](#)

[Хэлэлцүүлэг](#)

[Гадаад харилцаа](#)

**MMINFO.MN**

[Бидний тухай](#) | [Сурталчилгаа байршуулах](#) | [Вэб сайт хийх](#) | [Холбоо барих](#) | [RSS](#)  
Зохиогчийн эрх хуулиар хамгаалагдсан. Мэдээлэл хуулбарлах хориотой